



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/175

Улаанбаатар хот

Явуулын нэг цэгийн үйлчилгээ
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн өртөө, зөрлөгийн шугам замын иргэд, малчин, мал бүхий айл өрхүүдэд "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г 2024 оны 11 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, явах замын маршрутыг хоёрдугаар, зарцуулах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэхэд зарцуулагдах 622.000 (Зургаан зуун хорин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г чанар хүртээмжтэй хүргэж, тайлан, мэдээг нэгтгэж танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

АЖИЛ/2024 он ажил/захирамж

1123200340

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 24 ны өдрийн 1118 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:
Гишүүд:

Б.Болормаа

Б.Цогжавхлан
Ц.Алтантогос

Н.Нямзав
Б.Батзориг
Б.Цогбадрах
Т.Лхагвасүрэн
Ч.Магадсайхан
М.Уранцэцэг
Д.Энхтайван

Х.Ганбат
Б.Баяртуяа
Х.Анхбаяр
П.Цэрэнням

Нарийн бичиг:


Н.Батцэнгэл

Засаг даргын Эдийн засаг, нийгмийн
хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Хөдөө аж ахуйн тасгийн даргын албан
үүргийг хавсран гүйцэтгэгч
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Онцгой байдлын хэлтсийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Газар зохион байгуулалтын албаны дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Нийгмийн даатгалын газрын дарга
Татварын хэлтсийн дарга
Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч


Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 24 ны өдрийн 1115 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

1 ДҮГЭЭР ХОРООНЫ МАЛЧИН ӨРХ БОЛОН
ШУГАМ ЗАМЫН ӨРХӨӨР ЯВАХ МАРШРУТ



2 ДУГААР ХОРООНЫ МАЛЧИН ӨРХ БОЛОН
ШУГАМ ЗАМЫН ӨРХӨӨР ЯВАХ МАРШРУТ



Нийт туулах замын км-Талдаа $223 \times 2 = 446$ км

